

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТЭД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

| ТШЗ-ны холбогдох заалт | Өгөгдлийн хүснэгтэд тусгасан байсан шаардлага | Өөрчлөл орсон нь |
|------------------------|---|--|
| ТШЗ 18.1 | <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл "Шаардана"</p> <p>1. 2021, 2022, 2023 оны аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 80%-иас багагүй дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.</p> <p>2. Ижил төстэй гэдэгт тоолуур нийлүүлж байсныг ойлгоно.</p> <p>3. Бараа нийлүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолт (протокол эсхүл дүгнэлт эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг)-ын хуулбарыг нотариатаар гэрчлүүлж ирүүлнэ. (Хэрэв УБЦТС ТӨХК-тай байгуулсан гэрээ бол нотариатаар батлуулах шаардахгүй)</p> | <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл "Шаардана"</p> <p>1. Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэрээр батлагдсан төсөвт өртгийн 80%-иас багагүй дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.</p> <p>2. Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага гэдэгт тоолуур болон эрчим хүчний тоног төхөөрөмж нийлүүлж байсан туршлагыг ойлгоно. Үүнд ажил гүйцэтгэсэн туршлагыг тооцохгүй..</p> <p>3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, бараа хүлээлцсэн акт, гэрээ дүгнэсэн, протоколын хуулбарыг нотариат (тендер зарласан өдрөөс хойш хугацаатай байх)-аар гэрчлүүлж ирүүлнэ. Мөн.гэрээт бараагаа хугацаанд нь чанартай нийлүүлсэн эсэх тухай захиалагчийн тодорхойлолт (тендер зарласан өдрөөс хойш хугацаатай байх)-ыг ирүүлэх ба бараа нийлүүлснийг төлбөрийн баримт, и-баримтаар нотолж ирүүлнэ.</p> |
| | <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага "Шаардана"</p> <p>1. Борлуулалтын орлогын хэмжээ нь сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 80%-иас багагүй байх</p> <p>2. Тендерт оролцогч нь 2021, 2022, 2023 он тус бүр ашигтай ажилласан байна.</p> | <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага "Шаардана"</p> <p>1. Борлуулалтын орлогын хэмжээ нь сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 50%-иас багагүй байх</p> <p>2. Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 оны аль нэг жилд ашигтай ажилласан байна.</p> |
| ТШЗ 19.1 | <p>14. Оролцогч нь үйлдвэрлэгч/борлуулагчийн зөвшөөрлийг орчуулгын хамт ирүүлэх. Үүнд</p> <p>14.1 Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл гэдэгт:</p> <p>14.1.1 Оролцогч нь үйлдвэрлэгч бол нотлох баримтыг ирүүлнэ (нотлох баримт гэдэгт албан ёсны цахим хуудас, компанийн танилцуулга эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримтыг ойлгоно).</p> | <p>14. Оролцогч нь үйлдвэрлэгчийн дистрибьютерийн зөвшөөрлийг орчуулгын хамт ирүүлэх. Үүнд:</p> <p>Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл гэдэгт:</p> <p>14.1 Оролцогч нь өөрөө үйлдвэрлэгч бол нотлох баримтыг ирүүлнэ (нотлох баримт гэдэгт албан ёсны цахим хуудас, компанийн танилцуулга эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримтыг ойлгоно).</p> |

| | |
|--|--|
| <p>14.1.2 Оролцогч нь үйлдвэрлэгчээс зөвшөөрөл авсан бол үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл гэдэгт дараах баримтуудын аль нэг нь байж болно. Үүнд: албан бичиг, хамтын ажиллагааны гэрээ, бусад нотлох баримт,</p> <p>14.2 Борлуулагчийн зөвшөөрөл: гэдэгт:</p> <p>14.2.1 Оролцогч нь албан ёсны гэрээт борлуулагчаас зөвшөөрөл авсан бол дараах нотлох баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.</p> <p>14.2.2 Гэрээт борлуулагч нь үйлдвэрлэгчтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ эсхүл албан ёсны гэрээт борлуулагчийн гэрчилгээний хуулбар эсхүл албан бичиг, Оролцогч нь албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ эсхүл албан бичиг.</p> | <p>14.2 Оролцогч нь үйлдвэрлэгчийн дистрибьютерийн эрхтэй бол үйлдвэрлэгчийн дистрибьютерийн зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. Үйлдвэрлэгчийн дистрибьютерийн зөвшөөрөл гэдэгт дараах баримтуудын аль нэг нь байж болно. Үүнд: дистрибьютерийн гэрчилгээ, дистрибьютерийн хамтын ажиллагааны гэрээ, бусад нотлох баримт,</p> <p>14.2 Борлуулагчийн зөвшөөрөл гэснийг хассан.</p> |
|--|--|